



“ИНТЕР АУДИТ” ХХК

аудит, баталгаажуулалт, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ДАРХАН-СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

Оршил

Бид “Дархан-Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК /цаашид “компани” гэх/-ийн 2014.12.31-ний өдрийн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан болон мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд ба бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Удирдлагын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/-ын зарчмуудад нийцүүлэн бэлтгэж танилцуулах нь компанийн удирдлагын хүлээх үүрэг хариуцлага болно.

Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид буюу үнэн бодитойгоор бэлтгэх, дотоод хяналтын системийг зохион байгуулан, тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгож хэрэглэх ба болсон үйл явдалд тохиромжтой тооцооллуудыг хийж, эдгээрийн үр дүнг санхүүгийн тайланд шударгаар толилуулах зэрэг үүргүүд багтана.

Аудиторын хариуцлага

Бид гүйцэтгэсэн аудитынхаа үр дүнд тулгуурлан компанийн санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах үүрэгтэй.

Бид аудитыг Монгол улсын хууль, тогтоомж, Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/-ын хүрээнд, Сангийн яамнаас баталж мөрдүүлсэн заавар аргачлалын дагуу гүйцэтгэдэг. Эдгээр хууль, стандарт ба заавар аргачлалууд нь аудиторуудаас мэргэжлийн болон ёс зүйн зарчмуудыг баримтлах, санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаа ба зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар хангалттай бөгөөд зохистой нотлох баримтуудыг олж авах зорилгоор аудитыг урьдчилан төлөвлөж гүйцэтгэх, тохиромжтой горимуудыг хэрэгжүүлэхийг шаарддаг.



“ИНТЕР АУДИТ” ХХК

аудит, баталгаажуулалт, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээ

2

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН /үргэлжлэл/

Аудитын арга горимуудыг санхүүгийн мэдээллийн боловсруулалт, тайлагналын байдалд нийцүүлэн сонгож хэрэглэдэг бөгөөд, залилан ба алдаанаас шалтгаалах материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн судалгаа, тооцооллууд үүнд багтдаг. Аудитор тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтыг авч үзэх ба удирдлагын хийсэн томоохон дүн бүхий тооцоолол, сонгон хэрэглэж байгаа бүртгэлийн арга бодлогуудад үндэслэн санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлдэг.

Санал дүгнэлтийн үндэслэл

Гүйцэтгэсэн аудитын үр дүнд олж тогтоосон зүйлүүд ба тэдгээрт холбогдох баримт мэдээллүүд нь энэхүү дүгнэлт саналыг гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоонууд болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Аудитын дүгнэлт

Бидний үзэж байгаагаар аудит хийгдсэн “Дархан-Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК-ийн 2014.12.31-нээрх санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд санхүүгийн тайлангийн өдрөөр дуусгавар болгон бэлтгэсэн санхүүгийн байдал, жилийн орлого, зарлага, үр дүн өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ болон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн талаарх Монгол улсын хууль тогтоомж, Сангийн яамнаас баталж мөрдүүлсэн заавар аргачлалын дагуу үнэн бөгөөд бодитойгоор илэрхийлсэн байна.



ЗАХИРАЛ, МНБ

Л.ДОЛГОРСҮРЭН

2015.03.25



САНХҮҮГИЙН ТАЙЛАШГИЙН ХУРААНГУЙ /мян.төг/

"ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХК

/төгрөг/

Үзүүлэлт	2013-12-31	2014-12-31
А. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,475,013,048	836,063,156
Авлага	3,182,746,195	3,594,646,057
Бараа материал	841,627,234	824,620,152
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	9,311,071,551	516,532,556
Эргэлтийн хөрөнгийн дүн	14,810,458,029	5,771,861,922
Үндсэн хөрөнгө	21,184,586,207	59,365,906,068
Биет бус хөрөнгө	119,106,887	170,132,894
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	21,303,693,094	59,536,038,962
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	36,114,151,123	65,307,900,884
Богино хугацаат өглөг	15,772,051,338	5,099,565,185
Урт хугацаат өглөг	50,547,775	36,916,339
Өр төлбөрийн дүн	15,822,599,113	5,136,481,524
Өмч	5,390,833,424	5,390,833,424
Дахин үнэлгээний нөөц	15,317,874,703	58,751,009,125
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг	(417,156,116)	(3,970,423,190)
Эзэмшигчийн өмчийн дүн	20,291,552,010	60,171,419,359
НИЙТ ӨР ТӨЛБӨР	36,114,151,123	65,307,900,884

Б. ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Цэвэр борлуулалт	40,729,744,965	48,584,479,446
Борлуулалтын өртөг	32,263,606,132	35,325,571,620
Нийт ашиг /алдагдал/	8,466,138,833	13,258,907,825
Бусад орлого	6,441,086,867	1,932,777,834
Борлуулалт, маркетингийн зардал	8,679,342,105	7,915,212,889
Ерөнхий ба удирдлагын зардал	105,644,200	7,279,971,316
Бусад зардал	6,148,872,223	3,616,192,957
Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	131,418,066	68,724,701
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	104,785,238	(3,550,966,802)
Орлогын татварын зардал	148,505,780	2,300,271
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	(43,720,542)	(3,553,267,074)
Нэгж хувьцаанд ноогдох ашиг /алдагдал/		

В. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Эхний үлдэгдэл	21,509,105,395	20,291,552,010
Нэмэгдсэн		43,433,134,423
Хорог дсон	1,217,553,384	3,553,267,074
Эцсийн үлдэгдэл	20,291,552,010	60,171,419,359

Г. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(296,735,275)	2,257,488,524
Хөрөнгө оруулалт үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,043,302,002)	(1,453,299,308)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	2,572,548,523	(1,443,139,108)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,232,511,246	(638,949,892)